



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 17/2022

Мандалговь

“Хангда” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйл 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын фасадны засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Хангда” ХХК-тай 39,997,746 (гучин есөн сая есөн зуун ерэн долоон мянга долоон зуун дөчин зургаа) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу барилгын фасадны засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Хангда” ХХК-ний захирал (Г.Дашмаа)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн (М.Болор-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ

4822150282